

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн
6.3.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 200,000,000 /хоёр зуун сая / төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 150,000,000 /нэг зуун тавин сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 100,000,000 /нэг зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээ, үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээ нэмж эрхлэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 400,000,000 /дөрвөн зуун сая / төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 300,000,000 /гурван зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

